

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 11 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны зургаадугаар сарын 28-ны 10 цаг 10 минутад эхэлж, 11 цаг 25 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 15 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Гурвансайхан сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн дарга, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг дүнгийн тухай	Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Гурвансайхан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулалтад тэнцсэн Ломбо овогтой Уранчимэг, Шагдарсүрэн овогтой Энхсүх, Чимэд овогтой Бямбасүрэн, Жамц овогтой Нарантуяа, Мэндбаяр овогтой Алтанчимэг, Цэдэндамба овогтой Тогосмаа, Шаравжамц овогтой Оюун нарыг төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэж, ажлын байрны шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа Л.Уранбилэг, Ч.Бямбасүрэн, Ц.Тогосмаа нарыг Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Гурвансайхан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд харгалзан нэр дэвшүүлж, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн Энэбиш овогтой Одончимэг, Батмөнх овогтой Мөнхчимэг, Галхүү овогтой Энхдэлгэр, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Бүрэнбат овогтой Алдармаа нарыг тухайн албан тушаалд тус тус нэр дэвшүүлж, санал, дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх тухай тогтоолын төслүүдийг батлав.
2	М.Цолмонбаярын өргөдлийг хянан шийдвэрлэх комисс томилон ажиллуулах	Биеийн тамир, спортын газрын мэргэжилтнээр ажиллаж байсан М.Цолмонбаярын гомдлыг хянан шийдвэрлэх комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, журмын дагуу хянан шийдвэрлэж, дүнг 2017 оны 07 дугаар сарын 07-ны дотор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулах тогтоолын төслийг батлав.
3	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, Орон нутгийн өмчийн газрын дарга, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга, Биеийн тамир, спортын газрын дарга, Төв номын сангийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай	Төв номын сангийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн Цэрэн овогтой Одончимэг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлэх, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, Орон нутгийн өмчийн газрын дарга, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн Маам овогтой Цогзолмаа, Энхтуяа овогтой Одончимэг, Шижирбаатар овогтой Цэндболд, Ганбат овогтой Самданцоодол, Сүхбаатар овогтой Ууганбаяр,Баатар овогтой Мөнхжаргал төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэж, . Ажлын байрны шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа М.Цогзолмаа, Г.Самданцоодол, С.Ууганбаяр, Б.Мөнхжаргал тухайн албан тушаалд нв нэр дэвшүүлж, томилуулах санал, дүгнэлт, шийдвэрийг томилох эрх бүхий албан тушаалтанд уламжлах тухай тогтоолын төслүүдийг батлав.
4	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, Өлзийт сумын ЗДТГ-ын МЭҮТ-ийн даргад нэр дэвшсэн иргэдийг сонгон шалгаруулах комисс томилон ажиллуулах	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж , Сонгон шалгаруулалтыг 2017 оны 07 дугаар сарын 05-ны дотор зохион байгуулж, дүн тайланг 2017 оны 07 сарын 07-ны дотор салбар зөвлөлд танилцуулах тухай тогтоолын төслийг батлав.
5	Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтний албан	Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн Б.Баатарсүрэнг томилохоос татгалзсан шалтгаан нь хуулийн шаардлага хангахгүй байгаа тул урьд

	тушаалд нэр дэвшүүлсэн Б.Баатарсүрэнгийн тухай ирүүлсэн албан бичгийг хэлэлцэн шийдвэрлэх	гаргасан шийдвэрээ хүчинтэй гэж үзэв.
6	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд явуулсан мэргэшлийн шалгалтын дүнг танилцуулав.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА